

Сургалтын орчин, хэрэглэгдэхүүний бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, Дорж-Янжмаа Соёлмаа

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Ерөнхий боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах богино хугацааны төлөвлөгөө, арга хэмжээ боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах							
1	Ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициент, нэг ээлжээр хичээллэх сургуулийн боломжийг судалж, санал боловсруулна.	Ээлжийн коэффициентийн үнэлгээ, бүлэг дүүргэлтийн судалгаа, санал	-	Санал боловсруулсан байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициентийг 2023-2024 оны хичээлийн жилийн статистикийн мэдээлэлд үндэслэн (i) анги танхим ашиглалт, (ii) барилгын хүчин чадал ашиглалт гэсэн хоёр аргаар тооцлоо. Эдгээр үнэлгээний дүнг нэгтгэн нэгдсэн үнэлгээг тооцож гаргасан бөгөөд <1.1-ээс тохиолдолд “нэг ээлж”, 1.1-2.0 бол “хоёр ээлж”, 2.1-2.4 бол “судлах шаардлагатай”, 2.4-өөс дээш байгаа бол “яаралтай арга хэмжээ авах” гэсэн үзүүлэлтээр авч үзсэн. Тооцооллоор төрийн болон орон нутгийн өмчийн 695 сургуулийн 50.2 хувь буюу 349 (нийслэлд 35	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					сургууль) нь нэг ээлж, 46.3 хувь буюу 322 (нийслэлд 114) нь хоёр ээлжээр тус тус хичээллэх боломжтой бол 3.5 хувь нь нормативаас өндөр байна. Өөрөөр хэлбэл, ээлжийн ачаалал 2.48-3.68 буюу “яаралтай” ангилалд 9 (нийслэлд 6), 2.12-2.59 буюу “судлах шаардлага” ангилалд 15 (нийслэл 8) сургууль, нийт 24 сургууль нормативаас өндөр гэсэн үг. Харин ээлжийн ачааллын үзүүлэлт 1.1-ээс бага боловч хоёр ээлжээр хичээллэж байгаа 147 (нийслэлд 18) сургууль байна /саналыг хавсаргав/ Хавсралт: 1 файл		
2	“Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтэд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.	“Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөө	Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоол	“Эрүүл шүд” арга хэмжээний хэрэгжилтэд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлсэн байна.	Эрүүл мэндийн сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны А/27, А/25 дугаар хамтарсан тушаалаар “Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Олон нийтэд амны хөндийн өвчлөлөөс үүдэн учирч болох эрсдэлийн талаар таниулан, өвчлөлөөс сэргийлж, өдөр тутамд зөв дадал хэвшүүлэх зорилгоор “Шүд эрүүл бол бие эрүүл” аяныг үндэсний хэмжээнд хэрэгжүүллээ. Аяны хүрээнд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 200 эмчийг танхимын, орон нутгийн 350 эмчийг цахимаар, нийт 550 эмчийг сургалтад хамрагдлаа.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					Энэхүү аяны хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчдын 40.3 хувь нь буюу 351644 суралцагч шүд, амны хөндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. Эдгээр суралцагчдын 34.0 хувь нь буюу 122855 суралцагчийг эрүүл мэндийн байгууллагад холбон зуучилсан ба эдгээрийн 53.0 хувь нь буюу 65231 суралцагч шүдээ эрүүлжүүлж, амны хөндийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд 140733 эцэг эх, асран хамгаалагчид дэмжиж ажилласан байна. Ерөнхий боловсролын нийт сургуулийн 48.6 хувь буюу 430 сургууль шүд угаах цагийн зохицуулалт хийсэн байна. Нийт сургуулийн 17.1 хувь нь буюу 151 сургууль ариун цэврийн өрөөнөөс тусдаа 1548 шүд угаах цэг байгуулсан байна. Эдгээр сургуулиуд 1306 шүд угаах цэгийг өрөөнд, 240 шүд угаах цэгийг коридорт байгуулжээ. Бага ангийн суралцагчдын 17.7 хувь нь буюу 67253 суралцагч, дунд ахлах ангийн суралцагчдын 25.0 хувь буюу 106016 суралцагч сургуулийн орчинд шүдээ угааж хэвшсэн байна. Нийт сургуулийн 53.2 хувь нь буюу 470 сургууль шүд, амны хөндийн эрүүл мэндийг хамгаалахтай холбогдох сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдаж 66 сургууль 88.1 сая төгрөгийг сургуулийн нөөц, төсөл	
--	--	--	--	--	---	--

					хөтөлбөр, орон нутгийн төсөв, эцэг эх, асран хамгаалагчдын дэмжлэгтэйгээр зарцуулан зохион байгуулсан байна. Эрүүл шүд арга хэмжээний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж Боловсролын ерөнхий газартай хамтарч ажилласан. Хавсралт: 4 файл		
1.2. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг боловсронгуй болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх							
3	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүний бүртгэл, судалгаанд тулгуурлан авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулна.	Санал	-	Санал боловсруулсан байна.	Сургалтын хэрэглэгдэхүүний менежментийн платформ буюу Mlab 2.0 системээр төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын нийт 1953 нэр төрлийн 112805 хэрэглэгдэхүүний бүртгэл, шаардлага хангасан эсэх мэдээллийг бүртгэсэн. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүний хангалт 2.2-18.9 хувьтай, улсын дундаж 7.5 хувь байна. Баян-Өлгий аймаг хамгийн бага буюу 2.2 хувь, Сэлэнгэ аймаг хамгийн өндөр буюу 18.9 хувьтай байна. Сургалтын хэрэглэгдэхүүний төрлийн хувьд улсын дундаж 299, Баян-Өлгий аймагт хамгийн бага буюу 86, Сэлэнгэ аймагт хамгийн өндөр буюу 751 байна. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүний судалгааг хичээлээр нь гаргахад мэдээллийн технологи хичээлийн хэрэглэгдэхүүний хангалт	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хамгийн өндөр буюу 22.9 хувь, эрүүл мэндийн хичээлийн хэрэглэгдэхүүний хангалт хамгийн бага буюу 4.1 хувь байна. Байгалийн ухаан буюу физик, хими, биологийн хичээлийн хэрэглэгдэхүүний хангалт хамгийн бага буюу 5.7-6.7 хувь байна. Түүх, нийгмийн ухааны хичээлийн хэрэглэгдэхүүний хангалт 9.2-10.7 хувь, дизайн технологи, дүрслэг урлаг, зураг зүйн хичээлийн хэрэглэгдэхүүний хангалт 5.0-9.4 хувь, гадаад хэлний хичээлийн хэрэглэгдэхүүний хангалт 14.3-20.5 хувь, хөгжим, биеийн тамирын хичээлийн хэрэглэгдэхүүний хангалтын хувь 5.8-8.4 хувь байна. Сургалтын хэрэглэгдэхүүний хангалт 5.6-аас доош хувьтай 258 сургууль байгаа нь нийт сургуулийн 43.0 хувийг эзэлж байна. Сургалтын хэрэглэгдэхүүний хангалт 20-аас дээш буюу 20.0-66.0 хувьтай сургуулийн тоо 62 байгаа нь нийт сургуулийн 9.5 хувийг эзэлж байна. 2025 оны 1 дүгээр сард төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын хэрэглэгдэхүүний бүртгэлийг шинэчлэн хийснээр нэн шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт, суурь судалгааг гаргаж Хөрөнгө оруулалтын хэлтэстэй хамтарч ажиллана. Сургалтын		
--	--	--	--	--	---	--	--

					хэрэглэгдэхүүний судалгааны үр дүнг нэгтгэн, судалгааны үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулсан. Хавсралт: 1 файл		
4	Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн хүртээмжийг сайжруулахад удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.	УХЖТ 3.1.4	Сурах бичгийн хангалтын хувь бага анги -93 хувь, дунд, ахлах анги-80 хувь	Сурах бичгийн хангалт бага ангид 95.0 хувь, дунд, ахлах ангид 85.0 хувьд хүрсэн байна.	2024-2025 оны хичээлийн жилд улсын төсвийн 1.4 тэрбум, түрээсийн эргэлтийн сангийн 3.0 тэрбум, нийт 4.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр бага ангийн 25 нэрийн 657.0 мянган ширхэг, дунд, ахлах ангийн 124 нэрийн 74.9 мянган багц буюу 1.2 сая ширхэг сурах бичиг хэвлэгдсэн. "Сурах бичиг тээвэрлэн хүргэх" нээлттэй тендерт "Монгол шуудан" ХК шалгарч улсын төсвийн 400.0 сая, түрээсийн эргэлтийн сангийн 600.0 сая, нийт 1.0 тэрбум төгрөгийн зардлаар тээвэрлэн хүргэх гэрээ байгуулан 2024 оны 6 дугаар сард 800 орчим сургуульд сурах бичгийг хүргэсэн. Сурах бичгийн түгээлтийг тусад нь тендер зарлаж шалгаруулдаг болсноор сурах бичиг богино хугацаанд хэрэглэгчдийн гар дээр хүргэгддэг болсон. Аймаг, нийслэлийн Боловсролын газраас сурах бичгийн цахим бүртгэл, хяналтын системээр бага ангийн 1.1 сая ширхэг сурах бичгийн захиалга ирснээс 657.9 мянган ширхэг буюу 57.9 хувь,	5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					дунд ахлах ангийн 141.5 мянган багц сурах бичгийн захиалга ирснээс 74.9 мянган багц буюу 52.9 хувьд тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан хэвлэгдэн ЕБС-иудад хүргэгдсэн. 2019 онд хэвлэсэн сурах бичгийн ашиглалтын байдалд судалгаа хийсний үндсэн дээр 22.0 хувийг ашиглана гэж тооцсоноор 2024-2025 оны хичээлийн жилд дунд, ахлах ангийн сурах бичгийн хангалт 85.0, бага ангийн сурах бичгийн хангалт 97.0 хувийн хангалттай байна. “Эй плас интернэйшнл” ХХК худалдах сурах бичгийн захиалга, тооцоог цахимаар хийж сургуулийн хаягаар хүргэлт хийгдэж байгаа бөгөөд 6-12 дугаар ангийн 1000 орчим багц сурах бичгийг худалдан, хүргэх ажлыг зохион байгуулсан ЕБС-ийн суралцагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр Боловсролын ерөнхий газрын түрээсийн сурах бичиг хариуцсан мэргэжилтэнд чиглэл, зөвлөмж өгч хамтарч ажиллалаа. Боловсролын сайдын “Журамд нэмэлт оруулах тухай” 2024 оны А/113 дугаар тушаал, 2024 оны “Стандартын төсөл шинэчлэн боловсруулах тухай” А/214 дүгээр тушаалыг боловсруулан батлуулж холбогдох харьяа	
--	--	--	--	--	---	--

					байгууллагуудад хүргүүлсэн.		
1.3. Ерөнхий боловсролын салбарын нийтлэг харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг бодлогын удирдлага зохицуулалтаар хангах							
5	Ерөнхий боловсролын сурах бичгийн эх зохиох, хэвлэх, түгээх үйл ажиллагааны журам боловсруулна.	Журмын төсөл	-	Журам боловсруулсан байна.	Ерөнхий боловсролын сурах бичгийн эх зохиох, хэвлэх, түгээх үйл ажиллагааны журмын төслийг боловсруулан 2024 оны 10 дугаар сард Боловсролын яамны цахим хуудсанд байршуулан багш, удирдах ажилтан, номын санч нар болон олон нийтээс санал авсан. Журмын төслийг (i) нийтлэг зүйл, (ii) сурах бичгийн эх зохиох, сурах бичиг, (iii) багшийн номын эх бэлтгэх, хэвлэх, түгээх, (iv) сурах бичгийн ашиглалт, (v) сурах бичгийн бүртгэл, мэдээллийн сан, (vi) сурах бичгийн санхүүжилт, (vii) бусад гэсэн 7 бүлэгтэйгээр боловсруулсан . Журмын төслийг Боловсролын яам, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын ерөнхий газрын холбогдох албан хаагчид, аймаг, нийслэлийн боловсролын газрын сурах бичиг хариуцсан мэргэжилтнүүд, хэвлэлийн газрын төлөөллийг оролцуулан 7 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг тусган сайжруулсан. Мөн Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс тус бүр хоёр удаа бичгээр санал авч саналыг	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					журмын төсөлд тусгалаа. Ерөнхий боловсролын сурах бичгийн эх зохиох, хэвлэх, түгээх үйл ажиллагааны журмын төслийг байгууллагын Able системд байршуулсан бөгөөд холбогдох дарга нар хянаж байна. Хавсралт: 2 файл		
6	Ерөнхий боловсролын сургалтын байгууллагад сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг ЭЗХЯ, ГТСМТТ-тэй хамтран цахим хэлбэрт шилжүүлнэ.	Цахим систем ашиглалт	-	Цахим системээр сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шинээр авах, сунгах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна	Сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбоотойгоор Гааль татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн мэргэжилтнүүдтэй 10 гаруй удаагийн уулзалт, хэлэлцүүлэг хийсэн. Гадаадын хөрөнгө оруулалттай ерөнхий боловсролын сургууль, олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль, их сургууль, дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын сургууль, Засгийн хоорондын хэлэлцээрээр байгуулагдах ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын сургуульд олгох зөвшөөрлийн ажлын даалгаврыг боловсруулан ГТСМТТ-д хүргүүлсэн. Зөвшөөрлийн нэгдсэн сан буюу www.license.mn-д Боловсролын яамнаас сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан 59 байгууллагыг бүртгэсэн. www.license.mn-д зөвшөөрөл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хүсэхэд бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг тулгах, бичиг баримтыг шалгах, хянах, баталгаажуулах эрхийн тохиргоо хийх, зөвшөөрөл тус бүрээр турших зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Тус системээр ерөнхий боловсролын сургуулийн тусгай болон энгийн зөвшөөрөл шинээр авах, сунгах хүсэлтүүдийг хүлээн авч Боловсролын сайдын тушаалаар томилогдсон ажлын хэсэг бичиг баримтыг магадлан шалгаж, Зөвшөөрлийн тухай хуулинд заасны дагуу хуулийн хугацаанд нөхөн бүрдүүлэхээр хүсэлтийг буцаасан. Нөхөн бүрдүүлж ирүүлсэн бичиг баримтуудыг магадлан шалгаж ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Боловсролын сайдын тушаалаар 4 сургуульд олон улсын хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 1 сургуульд олон улсын хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх урьдчилсан зөвшөөрөл, их сургууль, дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрлийг 4 сургуульд шинээр олгосон. Олон улсын хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх 5 сургууль, гадаадын хөрөнгө оруулалттай 2 сургуулийн тусгай зөвшөөрөл, их	
--	--	--	--	--	--	--

					сургууль, дээд сургуулийн харьяа 1 ахлах сургуулийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрлийг сунгаж Зөвшөөрлийн цахим мэдээллийн санд мэдээллийг тухай бүрд нь оруулсан. Хавсралт: 1 файл		
3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
7	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Хууль тогтоомж, шийдвэр, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан	Хууль тогтоомж, шийдвэр, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хугацаанд нь чанартай тайлагнасан.	Хууль тогтоомж, шийдвэр, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хугацаанд нь чанартай тайлагнасан байна.	Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сар тутамд чанартай тайлагнасан. Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тайланг хугацаанд нь тайлагнав. Өвөлжилтийн нөхцөл байдлын судалгаа болон цаг үеийн шинжтэй бусад судалгаа мэдээг хугацаанд нь үнэн зөв нэгтгэн боловсруулж холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
8	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан	Албан бичгийн шийдвэрлэлт болон өргөдөл гомдол барагдуулалтын	Өргөдөл, гомдлыг хугацаанд нь, чанартай, бүрэн гүйцэд	Өргөдөл, гомдлыг хугацаанд нь, чанартай, бүрэн гүйцэд	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	хувь, Байгууллагын архивт өгсөн хадгаламжийн нэгжийн тоо	шийдвэрлэсэн. Архивт 39 хадгаламжийн нэгжийг хүлээлгэн өгсөн.	шийдвэрлэсэн байна.	хэрэгжилтийг ханган ажиллалаа. 2023 оны 38 баримтыг архивлаж архивын ажилтанд хүлээлгэн өглөө. Засгийн газрын 1111 төвөөр дамжиж ирсэн болон бусад хэлбэрээр ирүүлсэн 48 өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж хариуг нь хүргүүлсэн. Мөн 101 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж хариуг нь албан бичгээр хүргүүлсэн. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан. 2023 оны хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд нь үнэн зөв мэдүүлсэн.	6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 0%
9	Удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл,	Үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэсэн байх Мэдээлэл, судалгааг шуурхай, үнэн зөв гаргаж өгсөн байх	Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж мэдээлэл, судалгааг шуурхай чанартай гаргасан.	Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж мэдээлэл, судалгааг шуурхай үнэн зөв гаргасан байна.	2024 оны 4 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд Монголын багш нарын 8 дугаар их хурлын зохион байгуулалтыг хариуцсан ажлын хэсэгт орж ажилласан. Боловсролын багц хуулийг сурталчлах ажлын хүрээнд БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/61	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	судалгааг шуурхай, үнэн зөв гаргаж өгнө.				дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсэгт орж Багануур, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтнуудад сургалт зохион байгуулсан. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн мэдээллийг өгч, дадлага ажил удирдаж ажиллалаа. Цаг үеийн шинжтэй өвөлжилтийн нөхцөл байдлын судалгааг нэгтгэж танилцуулга бэлтгэн холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. Боловсролын шинэ сэргэлт 100 арга хэмжээг зохион байгуулахтай холбоотойгоор БШУЯ-нд ажиллаж байсан хүмүүсийн судалгааг 1997-2023 оны тушаалаас түүж гаргасан. Сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, сайдын зөвлөх, газар, хэлтсийн дарга, мэргэжилтэн, Төрийн захиргааны удирдлагын газрын ажилтнаар ажиллаж байсан 520 хүнийг судалгааг гарган холбогдох албан тушаалтнуудаар хянуулж байна. БШУЯ-нд одоо ажиллаж байгаа 122 хүний мэдээллийг нэгтгэн цахим нэрийн хуудас, ажлын үнэмлэхийг Эй Юү Ти Групп ХХК-аар хэвлүүлэх ажлыг зохион байгуулж дарга, мэргэжилтэн, ажилтнуудад хүлээлгэж өгсөн. “MNS 6781:2019 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур	11-р сар, 12-р сар	үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	--	--------------------	---

					байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага” стандарт, “MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” стандартын хэрэгжилтийг үнэлэх үзүүлэлтүүдийг боловсруулан 2024 оны 11 дүгээр сард төрийн болон төрийн бус өмчийн 883 сургуулиас боловсролын салбарын мэдээллийн системээр асуулга авч үр дүнг нэгтгэн боловсрууллаа. Төрийн албаны зөвлөлийн Боловсролын яамны дэргэдэх салбар зөвлөлийн тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэгт 4 удаа орж ажиллан шалгалтын тайлан бусад холбогдох материалыг бүрдүүлэн салбар зөвлөлд хүлээлгэн өгсөн.		
10	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь Иргэд, албан байгууллагаас хүссэн мэдээлэлд хариу өгсөн байдал	2023 оны байршсан мэдээлэл	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг яамны цахим хуудасд байршуулсан байна. Иргэд, албан байгууллагаас хүссэн мэдээллийг хууль, журмын хүрээнд өгсөн	"Ерөнхий боловсролын сурах бичгийн эх зохиох, хэвлэх, түгээх үйл ажиллагааны журам"-ын төслийг байгууллагын цахим хуудсанд байршуулан иргэд, олон нийт, боловсролын салбарт ажиллагсдаас санал авсан (линк: https://moe.gov.mn/post/161550). Боловсролын яамнаас олгосон тусгай болон энгийн зөвшөөрлүүдийн талаарх мэдээллийг зөвшөөрлийн цахим мэдээллийн сан www.license.mn болон байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулсан (линк:		

				байна.	organizations/tabs). Иргэд, албан байгууллагаас хүссэн мэдээллийг тухай бүрд нь холбогдох хууль, журмын хүрээнд албан бичгээр хүргүүлсэн.		
--	--	--	--	--------	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Боловсролын яам болон бусад байгууллагаас зохион байгуулах дунд, богино хугацааны сургалтад хамрагдана.	Мэргэжил дээшлүүлэх сургалт, байгууллагын мэдээллийн цагт хамрагдана.	Байгууллагын мэдээллийн цаг, мэргэжил дээшлүүлэх сургалтад бүрэн хамрагдсан.	Мэргэжил дээшлүүлэх сургалт, байгууллагын мэдээллийн цагт хамрагдана.	Байгууллагаас зохион байгуулсан мэдээллийн цагт бүрэн хамрагдсан. "Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвөөс зохион байгуулсан уулзалт, семинар", "Дотуур байрны стандартын хэрэгжилттэй холбоотой хийгдсэн судалгааны танилцуулах уулзалт", "Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага", "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр", "Хорин нэгдүгээр зууны боловсрол насан туршийн суралцахуй" сэдэвт сургалтуудад танхимаар болон цахимаар хамрагдаж мэдлэг, чадвараа дээшлүүллээ. Төрийн албаны зөвлөлөөс цахимаар зохион байгуулсан 7:4:10 сургалтуудад хамрагдсан. Кембриджийн боловсролын төвөөс зохион байгуулсан сурах бичгийн онлайн сургалтад 2024 оны 08 дугаар сарын 05-08-ны өдрүүдэд хамрагдсан.		
2	Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, ажлын чиг үүрэгтэй холбоотой ном, гарын авлагыг судална.	Шинээр батлагдсан хууль тогтоомж, шийдвэр, ажлын чиг үүрэгтэй холбоотой ном, гарын авлагыг судалж дүрэм журам боловсруулах, албан бичиг баримт боловсруулахад ашиглана.	Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, ажлын чиг үүрэгтэй холбоотой ном, гарын авлагыг судалсан.	Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, ажлын чиг үүрэгтэй холбоотой ном, гарын авлагыг судалсан байна.	Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичигт хийсэн шинжилгээний дүнгийн тайлан, сурах бичиг, сургалтын орчин, хэрэглэгдэхүүнтэй холбоотой батлагдаж мөрдөгдөж байсан тушаал, шийдвэрүүд, шинээр батлагдсан боловсролын салбарын чиглэлээр батлагдсан Засгийн газрын тогтоол, дүрэм журмуудыг уншиж судлан тушаал шийдвэр, бичиг баримт боловсруулахад ашигласан. Засгийн газрын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, боловсролын салбарын хөгжлийн түүхтэй холбоотой ном, эх сурвалжуудыг уншиж судаллаа. Боловсролын салбарт хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж, тушаал шийдвэрийн цахим сан үүсгэж албан хэрэгцээнд ашиглаж байна.		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Сургалтын орчин, хэрэглэгдэхүүний бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, Дорж-Янжмаа Соёлмаа
/...../ Огноо: